| **Dec** | ❑ Student parent meeting<br>❑ Term 1 break | ❑ EE First Draft<br>❑ Predicted grades submitted<br>❑ Term 1 break |

| | | |
|---|---|---|
| **Jan** | ❑ Interim Reporting<br>❑ EE First Reflection Session<br>❑ Formal CAS interviews with students<br>❑ Mock tests | ❑ TOK essay first draft<br>❑ Group 1 and 2 IAs due<br>❑ Mock examinations<br>❑ Interim Reporting |
| **Feb** | ❑ IB courses continue | ❑ EE Final Draft<br>❑ TOK final draft<br>❑ Group 3 and 5 IAs due |
| **Mar** | ❑ EE Proposal<br>❑ Mock tests<br>❑ Term 2 break | ❑ TOK course completed<br>❑ Group 4 IAs due<br>❑ Term 2 break |
| **Apr** | ❑ EE First Reflection Session | ❑ EAs start |
| **May** | ❑ Year 1 examinations | ❑ CAS presentations<br>❑ Final DP written examinations |
| **June** | ❑ End of Year Reporting<br>❑ Summer vacation | ❑ End of Year Reporting<br>❑ Graduation |

## ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРИЙН ЧУХАЛ ҮЙЛ ЯВДЛУУД 2021-2023

| Сар | DP1 (2021-2022) | DP2 (2022-2023) |
|---|---|---|
| **IX** | ❑ АйБи хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг танилцуулах<br>❑ АйБи хичээл эхлэх<br>❑ CAS хөтөлбөр эхлэх<br>❑ CAS эхний ярилцлага | ❑ ЕЕ анхны хувилбар хураалгана<br>❑ Уран зохиолын хичээлийн ахисан түвшний эссэ бичиж эхэлнэ |
| **X** | ❑ ЕЕ (судалгааны эссэ) хичээлийн танилцуулга | ❑ Уран зохиолын хичээлийн ахисан түвшний эссэний эхний хувилбар дуусна |
| **XI** | ❑ Хичээлээс гадуур ажлууд | ❑ ТОК үзэсгэлэн<br>❑ Уран зохиолын хичээлийн ахисан түвшний эссэний эцсийн хувилбар дуусна<br>❑ ЕЕ сүүлийн ярилцлага<br>❑ 3 ба 4 дүгээр бүлгийн хичээлүүдийн дотоод шалгалтын эхний хувилбар дуусна |
| **XII** | ❑ Туршилтын шалгалт<br>❑ Нэгдүгээр улирлын тайлан, дүн<br>❑ Нэгдүгээр улирлын амралт | ❑ Урьдчилсан дүн гарна |
| **I** | ❑ Эцэг, эх, асран хамгаалагч, сурагчидтай ганцаарчилсан уулзалт | ❑ ЕЕ эцсийн хувилбарыг АйБи-д илгээнэ<br>❑ ТОК эссэ эхний хувилбар дуусна<br>❑ Туршилтын шалгалт<br>❑ Явцын тайлан гарна |

| | | |
|---|---|---|
| | | ❑ Уран зохиол, англи хэлний хичээлийн дотоод шалгалтууд дуусна |
| II | ❑ АйБи хичээл үргэлжилнэ | ❑ Бизнес менежмент, түүхийн хичээлийн дотоод шалгалт дуусна<br>❑ Математикийн хичээлийн дотоод шалгалт дуусна |
| III | ❑ ЕЕ бичих сэдвийн санал<br>❑ Туршилтын шалгалт<br>❑ Хоёрдугаар улирлын тайлан, дүн<br>❑ Хоёрдугаар улирлын амралт | ❑ ТОК хичээл хаагдана<br>❑ Байгалийн ухааны туршилтат хичээлүүдийн дотоод шалгалт дуусна |
| IV | ❑ ЕЕ анхны ганцаарчилсан уулзалт | ❑ Гадаад шалгалт эхлэнэ |
| V | ❑ ЕЕ бичих албан ёсны төлөвлөгөөгөө танилцуулах<br>❑ Жилийн эцсийн шалгалт<br>❑ Гуравдугаар улирлын тайлан, дүн | ❑ CAS-ийн илтгэл<br>❑ Гадаад шалгалт дуусна |
| VI | ❑ Зуны амралт | ❑ Жилийн эцсийн тайлан, дүн<br>❑ Төгсөлт |

7.2. Procedures for students who hand in late formal IB work (except for formal IB examinations) are as follows:

7.2. Албан ёсны АйБи хөтөлбөрийн даалгавар ажлыг (АйБи хөтөлбөрийн албан ёсны шалгалтаас бусад тохиолдолд) хугацаанаас нь хоцорч өгсөн сурагчдад зориулсан арга хэмжээ дараахь байдлаар хэрэгжинэ:

7.2.1. Students should inform their subject teacher well in advance if there are extenuating circumstances for not meeting the deadline.

7.2.1. Хугацаандаа амжихгүй байх нөхцөл байдал үүссэн тохиолдолд сурагчид хичээлийн багшдаа урьдчилан мэдэгдэх ёстой.

7.2.2. If work is late, a teacher checks with the student first to find out the reason  and why this was not communicated before the deadline.

7.2.2. Хэрэв ажил хоцорсон бол багш нь эхлээд сурагчаас шалтгааныг тодруулж, яагаад хугацаанаас нь өмнө мэдэгдээгүй болохыг олж мэднэ.

7.2.3. The teacher makes every effort to ensure that students meet their obligation, to the point of setting new deadlines or imposing certain restrictions such as attendance at after-school study periods. New deadlines must be communicated to the DP coordinator once deemed necessary and final.

7.2.3. Багш нь хугацааг шинэчлэн тогтоох эсвэл хичээлийн дараах давтлагын ирц зэрэг тодорхой хязгаарлалт тогтоож, сурагчдыг хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт

тавина. Шинэ хугацаа тогтоох шаардлагатай гэж үзсэн бол эцсийн байдлаар дипломын хөтөлбөрийн зохицуулагчид мэдэгдэнэ.

7.2.4. If the teacher's efforts are unsuccessful, the teacher should inform the DP coordinator and homeroom teacher, and write the parent formally about the student's non-compliance.

7.2.4. Хэрэв багшийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй бол багш нь дипломын хөтөлбөрийн зохицуулагч болон ангийн удирдсан багшид мэдэгдэж, сурагч үүргээ биелүүлээгүй талаар сурагчийн эцэг эхэд албан ёсоор бичнэ.

## Eight. Students IB registration

## Найм. Сурагчийн АйБи бүртгэл

8.1. All DP students at Shine Ue School are considered full Diploma candidates when they enter Grade 11.

8.1. Шинэ Үе сургуулийн Дипломын хөтөлбөрийн бүх сурагчид 11-р ангид элсэн орохдоо бүтэн диплом горилогчид гэж тооцогдоно.

8.2. In the beginning of Grade 12, students consult with the DP coordinator and University counselor to decide one of three pathways in terms of IB registration:

8.2. 12-р ангийн эхэн үед сурагчид Дипломын хөтөлбөрийн зохицуулагч болон их сургуулийн зөвлөхтэй ярилцан АйБи хөтөлбөрийн бүртгэлийн гурван замын аль нэгийг шийднэ.

8.2.1. Full IB diploma: registration for all subjects and the Diploma core (TOK, EE, CAS)

8.2.1. АйБи хөтөлбөрийн диплом: бүх хичээл болон Дипломын хөтөлбөрийн цөм (TOK, EE, CAS) хөтөлбөрүүдийн бүртгэл

8.2.2. Individual course registration: registration in specific courses and/or core components

8.2.2. Аль нэг хичээлээр бүртгэл хийлгэх: тодорхой хичээл ба/эсвэл үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд бүртгүүлэх

8.3. Students may wish to revise their registration until the end of the first semester of Grade 12.

8.3. Сурагчид 12-р ангийн эхний улирал дуустал бүртгэлээ өөрчилж болно.

8.4. Student registration is formalized upon payment of necessary formal IB assessment fees to the school.

8.4. Сурагчийн АйБи хөтөлбөрийн шалгалтын бүртгэлийг АйБи хөтөлбөрөөс баталсан албан ёсны төлбөрийг төлсний дараа баталгаажуулдаг.

## Nine. School-based assessment

## Ес. Сургуулийн үнэлгээ

9.1. School-based assessment of student progress in the DP has three purposes:

9.1. Дипломын хөтөлбөрт, сурагчийн ахиц амжилтыг үнэлэх сургуулийн үнэлгээ нь дараах гурван зорилготой байна:

9.1.1. Reporting progress of learning

9.1.1. Сурах явцын талаар мэдээлэх

9.1.2. Providing formative assessment to formal IB assessment

9.1.2. Албан ёсны АйБи үнэлгээнд явцын үнэлгээ гаргаж өгөх

9.1.3. Reflecting student readiness for both formal IB assessment and prospective university courses of study

9.1.3. АйБи хөтөлбөрийн албан ёсны үнэлгээний шалгалт болон их сургуулийн сургалтын аль алинд нь сурагчийн бэлэн байдлыг хангах

9.2. School-based assessment of student progress in the DP is criterion-related, and provides a report of student's progress based on school-developed criteria developed using the DP assessment objectives and the task-specific criteria for each course (see Appendix C). The highest level of each criterion is 8 for each subject, and a best-fit judgment of student performance is made by the teacher based on school-based summative tasks performed within the term.

9.2. Дипломын хөтөлбөрийн сурагчийн ахиц дэвшлийг дипломын хөтөлбөрийн үнэлгээний зорилго, хичээл бүрийн даалгаварт тусгай шалгуурыг ашиглан сургуулийн гаргасан үнэлгээний үнэлэх нь шалгуур үзүүлэлтээр дүгнэн тайланг гаргаж өгдөг. Шалгуур тус бүрийн хамгийн өндөр түвшин нь хичээл тус бүрийн хувьд 8 байх бөгөөд сурагчийн гүйцэтгэлийг хамгийн оновчтой дүгнэхийг багш тухайн улирлын хүрээнд хийсэн сургуулийн үнэлгээний шалгуураар үнэлдэг.

9.3. Term-end and year-end examinations are employed as further summative tasks for judgment, based on the structure of IB formal examinations in each subject.

9.3. Улирал бүрийн болон жилийн төгсгөлийн шалгалтуудыг судлагдахуун бүрийн АйБи хөтөлбөрийн шалгалтын албан ёсны шалгалтын бүтцэд үндэслэн дүгнэх цаашдын нэгтгэх даалгавар болгон ашигладаг.

9.5. School-based assessments (mock tests and other school assessments) employs students' self-assessment and peer-assessment to familiarize students with both school-based assessment criteria and formal IB assessment criteria.

9.5. Сургуулийн шалгалт нь (туршилтын шалгалт болон бусад шалгалт) сурагчдыг сургуулийн үнэлгээний шалгуур болон албан ёсны АйБи хөтөлбөрийн шалгуурын аль алинтай нь танилцуулах зорилгоор сурагчдын өөрийгөө үнэлэх, үнэлгээг ашигладаг.

9.6. School-based assessment of student progress is recorded on Google Classroom. Both students and parents can assess and see the progress.

9.6. Сурагчдын ахиц амжилт шалгалтын үнэлгээг Гүүгл Классрүүм-д оруулдаг бөгөөд эцэг эх/асран хамгаалагч, сурагчид нэвтэрч болно.

9.7. School-based assessment of student progress in the DP helps students develop and practice ATL skills necessary to succeed in the course, and employs a variety of authentic, inquiry-based, and ATL skills-based tasks in order to assess student learning and prepare them for formal IB assessment tasks.

9.7. Сургуулийн шалгалт нь дипломийн хөтөлбөрийн сурагчдыг сурах чадварыг эзэмшин хөгжүүлж, төрөл бүрийн бодит, шинжлэх ухаанч арга барилд суурилсан, сурах арга барилыг дэмжсэн даалгавaруудаар АйБи хөтөлбөрийн албан ёсны шалгалтад бэлтгэдэг.

**THE ASSESSMENT IN THE DIPLOMA PROGRAMME**

Diploma students undertake a program of study designed to meet the IBO's requirements. In addition, students are required to submit Diploma components on specific dates. The IBO supports school submission dates and processes as having the same importance as IBO dates and processes. Please note the IBO is not flexible about these dates in any way. Failure to submit Diploma Programme requirements on the school due dates will result in a non-award of that subject and hence the Diploma (see the calendar of deadlines in SUS handbook for details of all school dates). All IBO paperwork must be signed and completed. Work that does not have the required paperwork completed will not be marked. Submission instructions:

ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГАЛТ

Дипломын хөтөлбөрийн сурагчид АйБи байгууллагын шаардлагыг хангахуйц сургалтын хөтөлбөрийн дагуу суралцдаг. Нэмж дурдахад сурагчид Дипломын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой өдрүүдэд ирүүлэх шаардлагатай. АйБи байгууллага нь сургуулийн элсэлтийн огноо, үйл явцыг АйБи байгууллагын огноо, үйл явцтай ижил ач холбогдолтой болохыг дэмжиж ажилладаг. IBO нь эдгээр огноонд ямар нэгэн байдлаар уян хатан ханддаггүй болохыг анхаарна уу. Дипломын хөтөлбөрийн шаардлагыг сургуулиас тогтоосон хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд АйБи диплом олгогдохгүй. (Сургуулийн дотоод шалгалтуудын хугацаагШинэ Үе сургуулийн АйБи хөтөлбөрийн гарын авлагаас харна уу). IBO-ийн бүх баримт бичигт гарын үсэг зурж бөглөсөн байх ёстой. Шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлээгүй ажлыг тэмдэглэхгүй. Оруулах заавар:

- All assessment must be submitted online to the IBO, by the due date and time (8.30 am unless informed otherwise).
- Бүх үнэлгээний даалгаврыг тогтоосон огноо болон цагт (өөрөөр заагаагүй бол 08.30 цагт) багтаан онлайнаар АйБи-д оруулах ёстой.
- IB Assessment must be uploaded for verification as directed by the DP Coordinator. Students must ensure they understand or know where to find the following information:
- АйБи хөтөлбөрийн үнэлгээг Дипломын хөтөлбөрийн зохицуулагчийн зааврын дагуу баталгаажуулах зорилгоор байршуулах шаардлагатай. Сурагчид дараах мэдээллийг ойлгох эсвэл хаанаас олж болохыг мэддэг байх ёстой:
- All requirements for Academic Honesty.
- Сурлагын шударга байдалд тавигдах бүх шаардлага.
- All requirements for IBO paperwork and administration. The IB DP Coordinator is responsible for ensuring all IBO regulations are adhered to.
- IBO-ийн бичиг цаасны ажил болон захиргааны ажилд тавигдах бүх шаардлага. IB дипломын хөтөлбөрийн зохицуулагч нь IBO-ийн бүх дүрэм журмыг мөрдүүлэх үүрэгтэй.
- Students and parents must fully understand and be prepared to work within these regulations for the Programme to achieve its aims.
- Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд Сурагчид болон эцэг эхчүүд эдгээр журмыг бүрэн ойлгож, үүний дагуу ажиллахад бэлэн байх ёстой.

## ASSESSMENT DURING YEARS DP1 AND DP2

The key purpose of assessments are to provide information on student achievement and progress in each course in relation to the syllabus standards and to report on the standard of performance attained at the end of the course. There are two types of assessment completed by IB students during the school IB Diploma Programme – School-Based Assessment and IB Assessment. School- Based Assessment School-Based Assessment is used by teachers at Shine Ue to indicate how well a student is progressing in a particular subject. These may replicate IBO style assessments answers or may be of an alternate nature. School-Based Assessment is required to assist teachers formulate the information required by the IBO.

## ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРИЙН I БОЛОН II-Р ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний гол зорилго нь сургалтын хөтөлбөрийн стандарттай уялдуулан хичээл тус бүрт сурагчийн ололт амжилт, ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгөх, сургалтын төгсгөлд хүрсэн гүйцэтгэлийн стандартыг тайлагнахад оршино. Сургуулийн АйБи дипломын хөтөлбөрийн үеэр АйБи сурагчдыг үнэлэх үнэлгээний хоёр хэлбэр байдаг - Сургуульд суурилсан үнэлгээ ба АйБи хөтөлбөрийн үнэлгээ. Сургуульд суурилсан үнэлгээг Шинэ Үеийн багш нар сурагчдаа тухайн хичээлээр хэр зэрэг ахиц дэвшил гаргаж байгааг харуулах зорилгоор ашигладаг. Эдгээр нь АйБи хөтөлбөрийн үнэлгээний

шалгалттай адил туршилтын шалгалт эсвэл өөр шинж чанартай байж болно. Сургуульд суурилсан үнэлгээ нь багш нарт АйБи байгууллагад шаардагдах мэдээллийг боловсруулахад нь туслах үүрэгтэй.

- School-Based Assessment is not optional. All IB Diploma candidates must undertake and complete all requirements for school-based assessments.
- Сургуульд суурилсан үнэлгээг заавал хийх шаардлагатай. АйБи хөтөлбөрийн дипломын бүх нэр дэвшигчид сургууль дээр суурилсан үнэлгээний бүх шаардлагыг хангаж, биелүүлэх ёстой.
- Appropriate medical documentation and the granting of extensions through the process outlined in Appendix 1 will be required for students missing school based assessments and deadlines.
- Албан ёсны тамга тэмдэгтэй эмнэлэгийн магадлагаа болон 2021-2023 Шинэ Үе сургуулийн АйБи хөтөлбөрийн гарын авлагад тусгасан *Хавсралт 1 буюу* хугацаа сунгуулах хүсэлтийг журмын дагуу бөглөн зөвшөөрөл авах шаардлагатай.
- Technical difficulties with computers, lifestyle choices like travel or early school holidays or activities and regular school commitments, are not acceptable excuses for missing school based assessment deadlines or lessons.
- Компьютертой холбоотой техникийн асуудал, аялал, сургуулийн өмнөх амралт эсвэл үйл ажиллагаа, сургуулийн хэвийн үйл ажиллагаануудад оролцох зэрэг амьдралын хэв маягийн сонголтууд нь сургуульд суурилсан үнэлгээний шалгалтын хугацаа эсвэл хичээлийг орхигдуулах үндэслэл биш юм.
- Failing to meet school based assessment requirements may severely affect students' chances of gaining the Diploma.
- Сургуульд суурилсан үнэлгээний шаардлагыг хангаж чадахгүй байх нь сурагчдын Диплом авах боломжид ноцтойгоор нөлөөлж болзошгүй юм.

## Ten. Standardization of assessment

## Арав. Үнэлгээний стандартчилал

All student work in the DP is subject to internal moderation. Internal moderation comes in three forms: teachers' standardization of assessment, self-assessment, and peer assessment.

Дипломын хөтөлбөрийн сурагчийн бүх ажил дотоод хяналтад орно. Дотоод хяналт нь багш нарын үнэлгээний стандартчилал, өөрийгөө үнэлэх, сурагчид бие биенээ үнэлэх гэсэн гурван хэлбэртэй байна.

10.1. Teachers' standardization of assessment ensures that teachers of the same course or subject group have a common and standard understanding of the tools used for assessment, i.e. IB mark schemes, IB assessment criteria, DP school-based assessment criteria. This ensures consistent standards for student assessment and informs programme development

and course design. Teacher's standardization of assessment occurs for selected summative assessment tasks, every DP internal assessment tasks.

10.1. Багш нарын үнэлгээг стандартчилснаар ижил хичээл эсвэл хичээлийн бүлгийн багш нар үнэлгээ хийхэд хэрэглэгдэх хэрэгслүүдийн талаархи нийтлэг, стандарт ойлголттой болох, өөрөөр хэлбэл АйБи хөтөлбөрийн оноожуулалтын схем, АйБи хөтөлбөрийн шалгуур, Дипломын хөтөлбөрийн сургууль дээр суурилсан үнэлгээний шалгуурыг хангаж өгдөг. Энэ нь сурагчийн үнэлгээний тууштай стандартыг хангаж, хөтөлбөр боловсруулах, хичээлийн загвар гаргахад тусалдаг. Багшийн үнэлгээний стандартчилал нь сонгосон нэгтгэн дүгнэх даалгавар, Дипломын хөтөлбөрийн дотоод үнэлгээний даалгавар зэрэгт тохиолддог.

10.2. Self-assessment is required of students when submitting work for summative assessment. Students are expected to apply tools used for assessment to ascertain their achievement level and to ensure that they share a common and standard understanding of the assessment tools with their teachers. This practice also allows students to produce and submit their best work.

10.2. Эцсийн үнэлгээний ажлыг ирүүлэхдээ сурагчид өөрийгөө үнэлгээг гаргах шаардлагатай. Сурагчид үнэлгээний явцад ашигласан аргачлалыг ашиглан тэдний амжилтын түвшинг тодорхойлж, үнэлгээний аргачлалын талаарх нийтлэг, стандарт ойлголтыг багш нартайгаа хуваалцаж байх ёстой. Энэхүү дадал нь сурагчдад ажлаа чанартай гүйцэтгэн, илгээх боломжийг олгодог.

10.3. Peer assessment is done selectively in both formative and summative tasks to allow students to apply common tools used for assessment and ensure a common understanding and interpretation of these tools.

10.3. Сурагч бие биенээ үнэлэх үнэлгээг сурагчдад үнэлгээ хийхэд ашигладаг нийтлэг хэрэгслийг ашиглах боломжийг олгох, эдгээр хэрэгслийн талаарх нийтлэг ойлголт, тайлбарыг хангах зорилгоор хэлбэржүүлэх ба нэгтгэх даалгаврын аль алинд нь сонгон хийдэг.

## Eleven. Reporting student progress

## Арван нэгэн. Сурагчдын ахиц дэвшлийг тайлагнах

11.1. All DP teachers are expected to provide timely and informative feedback on all student work.

11.1. Дипломын хөтөлбөрийн бүх багш нар сурагчийн бүхий л ажлын талаар цаг тухайд нь, дэлгэрэнгүй мэдээлэл өгч байх ёстой.

11.2. Progress reports are provided at the end of each trimester, followed by a parent-teacher conference.

11.2. Явцын тайланг улирал бүрийн эцэст гаргаж, дараа нь эцэг эхийн уулзалт зохион байгуулдаг.

11.3. Progress reports comprise a report for each course and DP core component and provide feedback on student progress in the assessment objectives and a projection of student performance in formal IB assessment.

11.3. Явцын тайлан нь хичээл тус бүрийн ахиц дэвшил, анхаарах шаардлагатай талууд, Дипломын хөтөлбөрийн цөм хичээлүүдийн хэсгээс бүрдэх АйБи хөтөлбөрийн албан ёсны шалгалтад сурагчийн гүйцэтгэлийн баримжаа олгодог.

11.4. The following is a sample of a progress report for a DP course at the end of a trimester:

11.4. АйБи хөтөлбөрийн улирлын төгсгөлийн тайлангийн загварыг доор харуулав:

## Twelve. Data analysis

## Арван хоёр. Мэдээллийн дүн шинжилгээ хийх

Teachers are expected to use internal school-based assessment data, the annual IB subject reports, and unit reflections to inform teaching and learning in the DP.

Багш нар сургуулийн дотоод сургалтын үнэлгээ, жил бүрийн Дипломын хөтөлбөрийн үнэлгээний тайлан, нэгж хичээлд хийсэн шинжилгээ зэргийг ашиглан Дипломын хөтөлбөрийн сурах, сургах үйл ажиллагааны талаар мэдээлнэ.

## Thirteen. Policies cross-reference

## Арван гурав. Харилцан хамааралтай журмууд

Language policy (2020)

Хэлний журам (2020)

Academic Honesty policy (2020)

Сурлагын шударга байдлын журам (2020)

Inclusion policy (2020)

Нэмэлт журам (2020)

IB DP assessment policy (2020)

АйБи дипломын хөтөлбөрийн үнэлгээний журам (2020)

## Fourteen. Homework

## Арван дөрөв. Гэрийн даалгавар

14.1 Homework is a variety of written and non-written assignments given by the teacher to develop the ability to comprehend, recall, solve problems, and analyze what you have seen in class outside of class. Homework should be tailored to the goals and objectives of providing students with the knowledge, skills, and practices they need to acquire following the subject's curriculum and should be designed to consider the specifics and differences of students' learning.

14.1 Гэрийн даалгавар нь хичээлийн бус цагаар хичээл дээр үзсэнээ бататган ойлгох, сэргээн санах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх зорилгоор багшийн өгсөн төрөл бүрийн бичгийн болон бичгийн бус даалгавар байна. Гэрийн даалгавар нь тухайн судлагдахууны сургалт хүмүүжлийн хөтөлбөрийн дагуу суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг олгох зорилго, зорилтод нийцсэн байх бөгөөд суралцагчдын сурах онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэж төлөвлөгдсөн байна.

14.2. Based on provisions 2.3.8 and 2.3.9 of the Order No. of A/528 of the Minister of Education, Culture and Science dated August 27, 2019, the homework load will be calculated according to the study time during the school week. When studying in the classroom, homework is given 0-1 time a week for the subject studied 1-2 hours, once a day for the subject studied 3-4 hours, and 1-2 times a day for the subject studied five or more hours per week.

14.2. БСШУС-ын сайдын 2019 оны 08 сарын 27-ны өдрийн А/528-р тушаалын 2.3.8, 2.3.9-р заалтыг үндэслэн гэрийн даалгаврын ачааллыг тухайн хичээлийн долоо хоногт судлах цагт тохируулан тооцно. Үүнд: Танхимаар хичээллэж буй үед долоо хоногт 1-2 цагаар судалдаг хичээл 0-1 удаа, 3-4 цагаар судалдаг хичээл 1 удаа, 5 болон түүнээс дээш цагаар судалдаг хичээл 1-2 удаа гэрийн даалгавар өгнө.

14.3. The amount of homework to be given to students per day and per week shall be organized as follows, taking into account the training content, the age, physical condition, developmental characteristics, and workload of the student. These include:

14.3. Суралцагчдад өгөх нэг өдөр болон 7 хоногт гүйцэтгэх гэрийн даалгаврын хэмжээг сургалтын агуулга, суралцагчийн нас, бие, хөгжлийн онцлог, ачааллыг харгалзан дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

| Grade<br>Анги | Total time (hours) students spend on homework per day<br>Суралцагчдын өдөрт гэрийн даалгавар гүйцэтгэхэд зарцуулах нийт хугацаа (цаг) | | Time (hours) students spend on homework per week<br>Суралцагчдын долоо хоногт гэрийн даалгавар гүйцэтгэхэд зарцуулах хугацаа (цаг) | |
|---|---|---|---|---|
| | Classroom<br>Танхим | Online<br>Цахим | Classroom<br>Танхим | Online<br>Цахим |
| IB program class<br>АйБи хөтөлбөрийн анги | 2 | 2 | 10 | 10 |

14.4. When giving homework, the teacher should plan the homework according to the following table, considering the time required to complete the homework.

14.4. Гэрийн даалгаврыг өгөхдөө багш дараах хүснэгтийн дагуу даалгавар гүйцэтгэх хугацааг харгалзан үзэж гэрийн даалгаврыг төлөвлөнө.

| № | **Task form**<br>**Даалгаврын хэлбэр** | **Time spent**<br>**Зарцуулах хугацаа** |
|---|---|---|
| 1 | Question with 2 right and wrong options<br>Зөв буруу 2 сонголттой асуулт | 20-30 seconds<br>20-30 секунд |
| 2 | Multiple options (based on facts)<br>Олон сонголттой (баримтад суурилсан) | 40-60 seconds<br>40-60 секунд |
| 3 | Fill in the blanks<br>Нэг үгээр нөхөх | 40-60 seconds<br>40-60 секунд |
| 4 | Multiple options (combined)<br>Олон сонголттой (нийлмэл) | 70-90 seconds<br>70-90 секунд |
| 5 | Matching (5-6 options)<br>Харгалзуулах (5-6 сонголт) | 2-4 minutes<br>2-4 минут |
| 6 | Short answer<br>Товч хариулт | 2-4 minutes<br>2-4 минут |
| 7 | Multiple options (calculated)<br>Олон сонголттой (тооцоололтой) | 2-5 minutes<br>2-5 минут |
| 8 | Sentence Problems (with simple arithmetic operations)<br>Өгүүлбэртэй бодлого (энгийн арифметик үйлдэлтэй) | 5-10 minutes<br>5-10 минут |

| | | |
|---|---|---|
| 9 | Short essay recording<br>Богино эсээ бичлэг | 10-20 minutes<br>10-20 минут |
| 10 | Data (graph) analysis<br>Өгөгдөл (график)-ийн шинжилгээ | 15-25 minutes<br>15-25 минут |
| 11 | Draw a model / write a term<br>Загвар зурах/нэр томьёо бичих | 20-30 minutes<br>20-30 минут |
| 12 | Detailed essay<br>Дэлгэрэнгүй эсээ бичлэг | 35-50 minutes<br>35-50 минут |

14.5. Students will not be given homework on public holidays and celebrations.

14.5. Бүх нийтээр тэмдэглэх баяр ёслол болон тэмдэглэлт өдрүүдэд сурагчдад гэрийн даалгавар өгөхгүй.

14.6. If the student is not doing his/her homework for the first time, the teacher will give him/her extra time and help with advice on things he/she does not understand. In case of non-completion of the second assignment or late submission, the homeroom teacher will be notified orally and in writing. If the student does not complete the assignment three or more times, the student will be notified by phone or letter to the parent or guardian.

14.6. Суралцагч аливаа хичээлийн гэрийн даалгаврыг эхний удаа хийж ирээгүй тохиолдолд хичээл заагч багш нэмэлт хугацаа өгч, ойлгоогүй зүйлс дээр зөвлөн тусална. Хоёр дахь удаагаа даалгавар хийгээгүй, хугацаа хоцроосон тохиолдолд анги удирдсан багшид аман болон бичгэн байдлаар мэдэгдэнэ. Гурав болон түүнээс дээш удаа даалгавар хийгээгүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч руу утсаар залгах, захидал илгээх зэргээр холбоо барьж мэдэгдэнэ.

**Fifteen. Committee reviewing this edition**

**Арван тав. Үнэлгээний журмыг хянан найруулах комисс**

15.1 This document and policy was created through teacher collaboration and further amendments will also be made through collaboration with teachers. The policy will be reviewed annually by the Head of the School, IB DP coordinator, and IBDP teaching staff of Shine Ue school. New DP teacher orientation will specifically include an assessment allotment.

15.1. Энэхүү гарын авлагыг Шинэ үе сургуулийн АйБи дипломын хөтөлбөрийн багш нарын хамтын ажиллагааны хүрээнд бүтээсэн бөгөөд цаашид багш нартай хамтран ажиллах замаар нэмэлт өөрчлөлт оруулах болно. Гарын авлагыг сургуулийн захирал, АйБи дипломын хөтөлбөрийн зохицуулагч, АйБи дипломын хөтөлбөрийн хичээлийн

багш нар жил бүр хянан засварлана. АйБи дипломын хөтөлбөрийн шинэ багш нарын чиг баримжаа үнэлгээний хувь хэмжээг тусгайлан оруулна.

## Sixteen. Roles and responsibilities for implementing, evaluating and reviewing the assessment policy and for training new teachers.

## Арван зургаа. Үнэлгээний журмыг хэрэгжүүлэх, үнэлэх, хянах

16.1. **Implementing.** All teachers are involved in the implementation of the policy. The policy will be referred to during staff meetings, assessment period and as necessary throughout the academic year. The policy will be shared with staff and parents. The policy will be made available to parents through the programmes guidebook and in a future update of the website.

16.1. **Хэрэгжүүлэх.** Журмыг хэрэгжүүлэхэд бүх багш нар оролцоно. Журмын талаар багш нарын хурлаар, үнэлгээний хугацаанд болон шаардлагатай бол хичээлийн жилийн туршид хэлэлцэнэ. Журмыг багш ажилчид болон эцэг эхчүүдэд хүргэнэ. Журмыг хөтөлбөрийн гарын авлага ба вебсайтын шинэчилсэн мэдээллээр дамжуулан эцэг эхчүүдэд хүргэнэ.

16.2. Evaluating and Reviewing. The DP Coordinator, school leadership team and teaching staff will review the assessment policy annually in a staff meeting.
16.2. Үнэлгээ ба хянан засварлах. Үнэлгээний журмыг АйБи дипломын хөтөлбөрийн зохицуулагч, сургуулийн удирдлага, багш ажилтнууд ажилчдын хурлаар жил бүр хянан засварлана.

16.3. Training new teachers. New teachers will be shown this assessment policy during their induction. New teachers will be given induction on the assessment process, including a copy of the SUS IBDP Handbook.

16.3. Шинэ багш нарыг сургах. Шинэ багш нар ажиллаж эхлэх үеэр энэхүү үнэлгээний журмыг танилцуулна. Шинээр ажилд орсон багш нарт үнэлгээний явцын танилцуулга, түүний дотор Шинэ Үе сургуулийн АйБи дипломын хөтөлбөрийн гарын авлагын хуулбарыг олгоно.

*Appendix 5*

## DP Course: Group 4 grade descriptors

## Дипломын хөтөлбөрийн хичээл: 4-р бүлгийн хичээлийн үнэлгээний тодорхойлолт

| Criterion Шалгуур | 2 | 3 | 4 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|
| Understanding of concepts & principles Ухагдахуун болон зарчмуудын талаарх ойлголт | Weak understanding of basic concepts and principles Суурь ойлголт, зарчмуудын талаар ойлголт сул | Partial understanding of basic concepts and principles Суурь ойлголт, зарчмуудыг хэсэгчлэн ойлгодог | Adequate understanding of most basic concepts and principles Ихэнх суурь ойлголт, зарчмуудын талаар хангалттай ойлголттой | Thorough understanding of concepts and principles Суурь ойлголт, зарчмуудыг сайтар ойлгодог | Thorough command of concepts and principles Суурь ойлголт, зарчмуудыг сайтар мэддэг |
| Subject knowledge Хичээлийн талаарх мэдлэг | Little knowledge of subject Хичээлийн талаар бага мэдлэгтэй | Limited knowledge of subject Хичээлийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй | Reasonable knowledge of subject with some gaps possible Багахан хоцрогдолтой боловч боломжийн мэдлэгтэй | Very broad knowledge of subject Хичээлийн талаар маш өргөн мэдлэгтэй | Comprehensive knowledge of subject Хичээлийн талаар цогц мэдлэгтэй |
| Comprehension and application Ойлголт ба хэрэглээ | Little evidence of application of basic concepts and principles Үндсэн агуулга, зарчмуудын хэрэглээ бага | Weak ability to apply basic concepts and principles Үндсэн агуулга, зарчмуудыг ашиглах чадвар бага | Limited ability to apply basic concepts and principles Үндсэн агуулга, зарчмуудыг ашиглах чадвар хязгаарлагдмал | Selects and applies relevant information, concepts and principles in most contexts Холбогдох мэдээлэл, агуулга, зарчмуудыг ихэнх нөхцөлд сонгож, ашигладаг | Selects and applies relevant information, concepts and principles in a wide variety of contexts Холбогдох мэдээлэл, агуулга, зарчмуудыг олон янзын хүрээнд сонгож, ашигладаг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Analysis, evaluation of data<br>Мэдээллийн дүн шинжилгээ болон үнэлгээ | Minimal ability to manipulate data<br>Мэдээллийг боловсруулах чадвар хамгийн бага | Some ability to manipulate data<br>Мэдээллийг боловсруулах чадвартай | Some analysis and evaluation of quantitative or qualitative data<br>Тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх чадвартай | Highly competent analysis and evaluation of quantitative and qualitative data<br>Тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх өндөр чадвартай | Thorough analysis and evaluation of quantitative and qualitative data<br>Тоон болон чанарын мэдээллийг нарийвчлан шинжлэх, үнэлэх чадвартай |
| Explanation and prediction<br>Тайлбар болон таамаглал | - | - | - | Constructs explanations of complex phenomena, makes appropriate predictions<br>Нарийн төвөгтэй үзэгдлийн тайлбарыг боловсруулж, зохих таамаглалыг дэвшүүлдэг | Constructs detailed explanations of complex phenomena, makes appropriate predictions<br>Нарийн төвөгтэй үзэгдлийн тайлбарыг нарийн боловсруулж, зохих таамаглалыг дэвшүүлдэг |
| Problem solving ability<br>Асуудал шийдвэрлэх чадвар | Little ability to solve problems<br>Асуудлыг шийдвэрлэх чадвар багатай | Solves some basic or routine problems<br>Зарим үндсэн эсвэл тогтсон асуудлыг шийддэг | Solves some basic or routine problems, limited ability to solve challenging or unfamiliar problems<br>Зарим үндсэн эсвэл тогтсон асуудлуудыг шийддэг, бэрхшээлтэй эсвэл танил бус асуудлуудыг шийдвэрлэх хязгаарлагдмал чадвартай | Solves basic or routine problems and evidences competency in solving problems that are challenging or unfamiliar<br>Үндсэн эсвэл тогтсон асуудлуудыг шийддэг ба бэрхшээлтэй эсвэл танил бус асуудлыг шийдвэрлэх чадвараа нотолдог | Evidences great proficiency in solving problems, including those that are challenging or unfamiliar<br>Бэрхшээлтэй эсвэл танил бус асуудлуудыг шийдэх чадвараа нотолдог |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Communication & terminology Мэдээлэл хүргэх ба мэргэжлийн хэллэг, нэр томьёо | Responses are often incomplete or irrelevant Хариултууд нь дадаа бүрэн бус эсвэл хамааралгүй байдаг | Communicates with a lack of clarity and some repetitive or irrelevant material Тодорхой байдал дутагддаг, давтагдмал эсвэл хамааралгүй материалтай харьцдаг | Communicates adequately, may lack clarity and some repetitive or irrelevant material Хангалттай хүргэдэг, ойлгомжгүй, зарим материад нь давтагдмал, хамааралгүй байдаг | Effective use of appropriate terminology and conventions Тохиромжтой нэр томъёо, тогтсон журмыг үр дүнтэй ашигладаг | Logical and concise, using appropriate terminology and conventions Логиктой бөгөөд товч тодорхой, тохиромжтой нэр томъёо, тогтсон журмыг үр дүнтэй ашигладаг |
| Insight and Originality Ойлголт ба шинэлэг байдал | - | - | - | Shows occasional insight and originality Ойлголт ба шинэлэг байдал үе үе харуулдаг | Shows insight and originality Ойлголт ба шинэлэг байдал харуулдаг |
| Awareness of environmental impact and ethics Орчны нөлөө болон ёс суртахууны мэдлэг ойлголт | Limited awareness of environmental and ethical implications Орчны нөлөө болон ёс суртахууны мэдлэг ойлголт хязгаарлагдмал | Occasional attention to environmental and ethical implications Хүрээлэн буй орчин, ёс суртахууны нөлөөллийг үе үе анхаарал хандуулдаг | Some attention to environmental and ethical implications Хүрээлэн буй орчин, ёс зүйн үр дагаварт зарим талаар анхаарал хандуулдаг | Significant attention to environmental and ethical implications Хүрээлэн буй орчин, ёс зүйн нөлөөлөлд ихээхэн анхаарал хандуулдаг | Considerable attention to environmental and ethical implications Хүрээлэн буй орчин, ёс зүйд ихээхэн анхаарал хандуулдаг |

## Reference

## Ашигласан материалын жагсаалт

Khandjav, T. (2018). *SUS assessment policy.* Shine Ue School. *Retrieved January 22, 2021.*

Т.Ханджав, (2018). *Шинэ Үе сургуулийн үнэлгээний журам 2019.* Шинэ Үе сургууль. *Мэдээллийг ашигласан огноо 2021 оны 1-р сар сарын 22.*

International Baccalaureate Organization (2021). *The IB Learner Profile. Retrieved April 8, 2021 from* https://www.ibo.org/globalassets/publications/recognition/learnerprofile-en.pdf.

International Baccalaureate Organization. (January 22, 2021). *DP1 assessment outline. Retrieved January 22, 2021.*

АйБи ОУБ. (2021 оны 1 сарын 22). *Дипломын хөтөлбөрийн 1 дэх жилийн үнэлгээний зорилт. Мэдээллийг ашигласан огноо 2021 оны 1 сарын 22*

Shine Ue School (2019). *DP Assessment policy 2019. Retrieved April 8, 2021.*

Queensland Academy for Science Mathematics and Technology (2021). *IBDP assessment guidance handbook 2021. Retrieved April 8, 2021.*

International Baccalaureate Organization (2019). *DP General Regulations. International Baccalaureate Organization. Retrieved April 8, 2021.*

International Baccalaureate Organization (2017). *DP Grade Descriptors. International Baccalaureate Organization. Retrieved April 8, 2021.*

International Baccalaureate Organization (2015). *DP: From principles into practice. International Baccalaureate Organization. Retrieved April 8, 2021.*

International Baccalaureate Organization (2018). *Diploma Programme Assessment Procedures. International Baccalaureate Organization. Retrieved April 8, 2021.*

International Baccalaureate Organization (2010). *Guidelines for developing a school assessment policy in the Diploma Programme. Retrieved April 8, 2021.*